



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/МБ

Чойр

Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам" А/187 дугаар тушаал, 2023 оны "Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журам" А/112 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Самбазана ХХК нь (4615255) Сүмбэр сумын 1 дүгээр багт Ган зам 9 дүгээр гудамжны 907 тоотод байрлах аж ахуйн хашааны зориулалттай 59432м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тул газар ашиглалтын зориулалтыг өөрчлөн агуулах, агуулахын байгууламжийн зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар сунган эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Самбазана ХХК-ийн гүйцэтгэх захирал (Г.Ганбаяр)-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй Самбазана ХХК-нд эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудас болон газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Отгончимэг)-д зөвшөөрсүгэй.


4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/190 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400258



Аймгийн Засаг даргын 2024 оны  
03... сарын 21-ны өдрийн 1116 дугаар  
захирамжийн хавсралт



Самбазана ХХК-ийн эзэмшил газрын хугацааг сунгаж  
буй газрын байршлын зураг

Сумын нэр	Багийн дугаар	Газрын хэмжээ /м <sup>2</sup> /	Эзэмших хугацаа /жил/	Газрын зориулалт	Газрын байршил, нэр
Сүмбэр	1	59432	15	Агуулах, агуулахын байгууламж	Ган зам 9-907 тоот

